



АЖЛЫН БАЙРНЫ СУЛ ОРОН ТООНЫ ЗАР

Ажлын байрны нэр:

**ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ХЭЛТЭСТ-АРХИВ, МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМ ИЙН ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Гүйцэтгэх үндсэн үүрэг**

1. Архив, мэдээллийн сангийн удирдлагын системүүдийн хэвийн ажиллагаа, тоног төхөөрөмж, систем, сүлжээ, программ хангамжийн тасралтгүй ажиллагааг хангах, администраторын үүргийг гүйцэтгэх

2. Мэдээллийн нэгдсэн санг үнэн зөв мэдээллээр баяжуулах, нэгтгэх, боловсруулах ажлыг гүйцэтгэх, үүнтэй холбоотой шинэ технологи, программ хангамж боловсруулах, турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх

3. Мэдээллийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг сайжруулах, түүнд чиглэсэн заавар, журам, гарын авлага боловсруулах

Ажлын байранд тавигдах шаардлага:

1. Мэргэжил: Хүрээлэн буй орчин судлал /0521/, Цаг уур судлал /053210/, Уур амьсгал судлал /053212/, Ус судлал /053211/, Өгөгдлийн сан, сүлжээний загварчлал ба удирдлага /0612/, Программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт ба шинжилгээ /0613/.
2. Боловсрол: Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх
3. DBMS буюу Өгөгдлийн санг удирдах систем MSSQL, MySQL, PostgreSQL ажиллах чадвартай байх
4. Хариуцсан ажлаа төлөвлөх, зохион байгуулах, өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх, шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх
5. Мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн болон харьцуулсан шинжилгээ хийх, судалгааны үр дүн, шийдлийн хувилбаруудын үр дагаврыг харьцуулан үнэлэх чадвартай байх
6. Хувийн зохион байгуулалт сайтай байх

Бусад шаардлага:

- Шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх;
- Албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;
- Илүү цагаар ажиллах, ажлын ачаалал даах чадвартай байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 600 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын дагуу)
- Дипломын хуулбар,
- Цахим үнэмлэхийн хуулбар,
- Нийгмийн даатгалын дэвтрийн эхний хуудас болон томилгооны талаарх бичилт хийсэн хуудаснуудын хуулбар
- Тухайн ажлын байранд орох хүсэлт /өөрийн мэдлэг, ур чадвараа илэрхийлсэн өргөдөл/
-Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт (E-Mongolia-аас татаж авах)
Жич: Ирүүлсэн баримт бичгийг буцаан олгохгүй мөн дутуу ирүүлсэн материалыг сонгон шалгаруулахгүй болохыг анхаарна уу.

Материал хүлээн авах:

Ажиллах хүсэлтэй, шаардлага хангаж байгаа иргэн холбогдох баримт бичгийг

Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Жуулчны гудамж-5, Бага тойруу-3, Цаг уур, орчны шинжилгээний газрын өргөтгөлийн 605 тоотод авчирч өгөх эсхүл enkhchimeg@namem.gov.mn цахим шуудангаар ирүүлнэ үү.

Хугацаа 2025.12.12-ны өдрийн 17:00 цаг хүртэл

Холбоо барих утас: 51-264692